



БУЛГАН АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 13-ны өдөр

Дугаар А/17

Булган

Гэрээ байгуулах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 400 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны “Санхүүжилтийн хуваарь батлах тухай” А-352 дугаар тушаал, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2020 оны “Санхүүжилт хуваарилах тухай” А-14 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дашинчилэн суманд Мах- ноосны чиглэлийн хонины аж ахуйг хөгжүүлэх зорилгоор “Баяд” үүлдрийн хурган хуц худалдан авах ажлыг 9 500 000 /Есөн сая таван зуун мянга/ төгрөгөөр “Хужирын адаг” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг Мал үржлийн алба /М.Жавзандолгор/-д олгосугай.
2. “Баяд” үүлдрийн хурган хуц худалдан авах ажлын зардлыг хөтөлбөрийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Ерөнхий санхүүч /Л.Отгон/-д зөвшөөрсүгэй.
3. Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулахыг Мал үржлийн алба /М.Жавзандолгор/-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, аж ахуйн алба /Ч.Шүрэнцэцэг/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.АМГАЛАН